

Ш. Бира

### МАОИЗМ БА БНХАУ ДАХЬ ҮНДЭСТНИЙ АСУУДАЛ\*

Орчин үед марксизм-ленинизмд гүнээ харш, дайсагнагч үзэл санаа улс төрийн урсгалуудын нэг бол одоогийн Хятадын удирдлагын онол, практикийн үндэс нь болсон маоизм мөн.

Маоизм дэлхийн империалист харгислалын талд илтээр орж түүний социализмыг эсэргүүцсэн, хувьсгалын эсэргүү шинж чанар нь улам гүнзгийрч байгааг одоогийн үйл хэрэг бүрэн гэрчилж байна.

Социалист Вьетнамын эсрэг явуулсан хятадын зэвсэгт түрэмгийлэл, өөрсдийгөө бага улс, ард түмний эрхийг хамгаалагч гэж хуурамчаар зарлаж байдаг Хятадын удирдлагын багийг нүүрнээс нь бүрэн хуулж хаялаа. Социалист орнуудын нөхөрлөлийн тэгш эрхт гишүүн улсын эсрэг явуулсан энэ түрэмгийлэл, Хятад улс социалист орнуудын эсрэг явуулж ирсэн үзэл суртлын тэмцлээсээ цэрэг-улс төрийн тэмцлийн, аргад шилжсэнийг харууллаа.

Энэ оны 4-р сарын 25-нд хуралдсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр нөхөр Ю. Цэдэнбал: «Хятадын эрх баригчид марксизм-ленинизмийн сургаал, интернационализмын үзэл санаа, зарчмаас бүрмөсөн урван тэрслэлээ. Хятадын эрх баригч бүлгийнхний дотоод гадаад бүх бодлого ангийнхаа болон социалист мөн чанараа алдаад удаж байна.

Бээжингийн эрх баригч бүлгийнхэн хорон санаат их гүрний дээрэнгүй зорилго санаархалдаа хөтлөгдөн эх орноо социализмаас улам хөндийрүүлэн холдуулж, социалист улсуудтай харилцаагаа улам хурцатгаж байна. Хятадын эрх баригч дээд бүлгийнхэн орчин үеийн хүнлэг биш хамгийн харгис этгээдтэй эвсэн сүлбэлдэж, энх тайван социализмын дайсны лагерт илэрхий шилжжээ. Хятад улс ингэж ард түмнийхээ хүсэл зориг, эрх ашгаас тэрслэж, олон улсын империализмын дотны холбоотон болоод байна»<sup>1</sup> гэж хэлсэн билээ.

Хэдийгээр Хятадын удирдагчид, маоизмыг өөрсдийн алсын прагматик хэрэгцээнд тохируулан ашиглахын тулд Мао Зэдүний нэгэнт сүйрсэн зарим нэг номлолоос ухарахад хүрсэн боловч ерөөс маоизмын мөн чанар нь өөрчлөгдөөгүй хэвээрээ байгаа юм. Хятад орны төрийн тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөг хангах явдал удаан хугацааны турш үндсэн зорилго нь болж байсан хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн явцад маоизм нь үзэл санаа-улс төрийн урсгал болон үүсэн бүрэлдсэн ажээ. Уг чанартаа үндэсний энэ зорилгонд тулгуурлан хятадын хувьсгалын нийгэм-улс төрийн зорилтыг шийдвэрлэж байсан юм гэж хэлж болно. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд татагдан орсон, пролетари биш давхрагын олон түмэн Хятад дахь хувьсгалын үндэсний болон нийгмийн үүргийг өөр өөрийнхөөрөө төсөөлөн ойлгож байсан юм. Иймэрхүү ойлголт л маоизмын үзэл санаа, улс төрийн онолд хамгийн тодоор тусгалаа олсон

\*1979 оны 5-р сарын 29-нөөс 6-р сарын 1-нд Улаанбаатарт «Маоизм ба үндэстний асуудал» хэмээх сэдвээр болсон социалист орнуудын олон улсын эрдэм шинжилгээний симпозиумд тавьсан үндсэн илтгэл.

<sup>1</sup> Ю. Цэдэнбал. Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны V бүгд хурлыш материал. УБ., 1979. 29-р, тал.

юм. Хоцрогдсон Хятад орны нөхцөлд жижиг хөрөнгөтний үндэсний хувиа хичээх үзэл, хэт хувьсгалчирхан хэт хүчирхийлэх чанар, хятадын уламжлалт угсаатан төвт үзэлтэй (этноцентризм) нийлж их гүрний үндэсний дээрэнгүй үзлийн нэг онцлог хэлбэр болсон их хан үндэстний дээрэнгүй үзлийг үүсгэжээ. Эдүгээ маоизм бол харгис социал-шовинизм, дайнч түрэмгий ноёрхох бодлогын хэлбэрийг олсон их гүрний үндсэрхэх үзэл гол шинж нь болсон, жижиг хөрөнгөтний үндэсний үзэл санаа-улс төрийн нэгэн урсгал болж байна.

Их хан үндэстний дээрэнгүй үзлийн ард түмний эсрэг хандсан харгис мөн чанар, үндэсний асуудлын талаар маоистуудын явуулж байгаа бодлогод бүр ч хурц тодоор илэрч байгаа юм. Энэ бодлогод гүнзийн уламжлалт үзэл мэтийн сургаалын сан хөмрөгөөс Мао Зэдүн болон түүнийг залгамжлагчдын өвлөн авсан их гүрний дээрэнгүй үзэл болон хятад төвт үзэл, нэвт шингэсэн байна. Зөвлөлтийн болон социалист бусад орны эрдэмтний бүтээлд, маоизмын нийгэм-сэтгэл зүй, үзэл санааны эх сурвалжийг олж илрүүлэхэд ихээхэн анхаарч байна. Тухайлбал, маоизм гүнзийн сургаалтай нягт холбоотой болох нь батлагдав. Гэхдээ маоизмыг тэр аяар нь гүнзийн сургаалтай адилтган үзэж болохгүй нь мэдээж хэрэг. Гүнзийн сургаал гол төлөв хүмүүсийн нийгмийн сэтгэл зүй, сэтгэн бодохын уламжлалт арга төрхөөр дамжин маоизмд нөлөөлсөн ажээ. Бидний бодож байгаагаар маоистуудын үндэсний бодлогод хэдэн зуун жилийн турш Хятад дахь янз бүрийн үндсэрхэх харгис үзэлтний их хан үндэсний дээрэнгүй үзлийн онолын үндэс болсоор ирсэн гүнзийн сургаалын угсаатан төвт үзэл нь л илүү хүчтэй, шууд нөлөө үзүүлсэн юм.

Гүнзийн сургаалын угсаатан төвт үзлийн үндэс нь орчлон ертөнц, Хятадын эзэнт улс хоёрыг нэгэн адил болгон үздэг, «Тянься» хэмээх ертөнцийн тухай, онол мөн. Гүнзийн сургаал ёсоор бүх ертөнцийн хүн төрөлхтнийг «хятад хүн», «зэрлэг хүн» гэж хоёр хувааж, Хятад орноос хол, ойр аль нэгэн газар оршин сууж байгаа хятад биш хүн ардыг «зэрлэгүүд» гэнэ. Гүнзийн сургаал ёсоор бүх ертөнцийн хүмүүсийг «Тэнгэрийн хүү» буюу Хятадын эзэн хаан захирах ёстой бөгөөд Хятад орон дэлхийн «төв» учраас «Чжунго» буюу «Дундат улс» мөн, харин бусад бүх орон «Тэнгэрийн хүүгийн» ертөнцийг засан тохинуулах нөлөөн дор орших ёстой «зэрлэг» улс гэнэ. Гүнзийн сургаалаар бол «зэрлэгүүд» нь уг чанартаа хүмүүс биш ажээ. Ийнхүү гүнзийн сургаал ёсоор Хятадаас өөр биеэ даасан улс түмэн байхгүй, хятадынхаас өөр улс төр байхгүй, хятадынхаас өөр соёл иргэншил ч байхгүй байх ёстой болж байна. Хятад дахь хятад биш цөөнх ард түмний<sup>1</sup> талаар маоистуудын баримтлан явуулж буй их гүрний үндэсний дээрэнгүй бодлого, хятад биш цөөнх ард түмний биеэ даан төр улс, нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх авьяас чадварт нь үл итгэх, хятад биш цөөнх ард түмэн бол хятадын соёл иргэншлийг зөвхөн хүлээн авагч төдий байх ёстой мэтээр үзэж, соёл, ахуй амьдралын нь үндэсний онцлогийг үгүйсгэх, хүний хамгийн наад захын эрхийг нь ч бүдүүлгээр зөрчих, үндэсний бахархлыг нь доромжлох, уугуул нутгийнхныг хүчээр уусгах, хүн амын нийгэм-соёлын амьдралын бүх талыг албадан хятадчилах арга хэмжээ явуулах зэрэг нь цөм гүнзийн их гүрний дээрэнгүй үзэл санаа-маоизмын онол практикт үнэхээрийн хүчтэй нөлөө үзүүлснийг гэрчилж байгаа юм.

Хятад хүний үндэсний ухамсар, сэтгэл зүйд оршиж байгаа хуучны үлдэгдэл, хятад төвт үзлийн амь бөхтэй дадал заншил болон мөн хятадын соёл бол хамгийн эртний, хамгийн өндөр хөгжилтэй учраас хятад биш бүх «зэрлэг» зүйлийг уусган шингээх чадвартай гэх буюу хятад үндэстэн хэмжээний хувьд хамгийн олон, угсаатны хувьд нэг төрлийн бүхэл бүтэн

<sup>1</sup> «Хятад биш ард түмэн» гэсэн утгаар бид «хан» биш үндэстэн ястанг нэрлэнэ.

цул учир бусад улс түмэн түүнийг хүрээлэн нэгдэх ёстой гэдэг эртнээс даамжран архагшсан бодол санааг маоизм аль болохоор ашиглан дэвэргээж байна.

1966 онд Мао Зэдүн хэлсэн нь: «Ирээдүйд хятад үндэстний дотор бусад ямар ч үндэстнээс илүү их тууштай өөрчлөлт гарна. Хятад үндэстний нийгэм бусад ямар ч үндэстнийхээс илүү туяаран гэрэлтэнэ. Хятад үндэстний аугаа их нэгдэл бусад ямар ч газар орон, ямар ч үндэстнийхээс илүү түргэн амжилттай явагдаж дуусана»<sup>1</sup> гэжээ.

Маоизм хичнээн их хэт хувьсгалч дүр үзүүллээ ч гэсэн хятадын их гүрний уламжлалт үндэсний дээрэнгүй үзлээс татгалзаж чадаагүй бөгөөд тэр нь өөрийн царайг орчин цагийн маягаар тун болхи халхалсан, мөн Хятад дахь хятад биш ард түмний талаар явуулж буй үндэсний дээрэнгүй харгис бодлогыг амьдралд хэрэгжүүлэх онол, практикийн удирдамж болсон үндсэрхэх сургаал болон нэгэнт хувирчээ.

Хятад улсын нөхцөлд үндэсний асуудлыг зөвөөр шийдвэрлэх явдал үлэмжхэн төвөгтэй асуудал гом. Хятад оронд 50 гаруй үндэстэн ястан амьдардаг билээ. Хятадын сүүлийн үеийн хэвлэлийн мэдээжийн багасгасан тоо баримтаар бол, тус орны бүх газар нутгийн 60 шахам хувийг эзлэн сууж байгаа хятад биш хүний тоо 50 саяас цөөнгүй байна. Хятад биш хүмүүс, хятадын эрх баригчдын зүгээс олон зуун жилийн турш явуулж ирсэн үндэсний болон нийгмийн дарлалын дор далхигдаж байсан учир түүхэн хөгжлөөрөө үлэмж их хоцрогдсон байна. Тэд феодалын нийгмийн харьцаа, феодалын нийгмийн түрүүч үеийн хөгжлийн түвшинд байсан юм. Нөгөө талаас хятад биш ард түмний дийлэнх нь соёл, зан заншил, угсаа, хэл, шашны онцлогоороо ханчуудаас онцгой ялгаатай бөгөөд саяхан хүртэл, Хятадын түүхэн хөгжлөөс хамаарахгүйгээр, биеэ даан хөгжиж байжээ. Түүхийн хувьд эдгээр ард түмэн зэргэлдээ улс орны ард түмэнтэй нягт холбоотой байв. Жишээлбэл: Төвд Энэтхэгтэй түүх-соёлын талаар ямаршуу харилцаатай байсан нь хүн бүхэнд илэрхий билээ. Уйгур болон бусад түрэг угсаатай ард түмэн Зөвлөлтийн Дундад Ази, Казахстаны ард түмэнтэй, Өвөр Монголчууд БНМАУ-ын ард түмэнтэй бүр ч ойр дотнын хэлхээ холбоотой байсан юм. Хятад биш ард түмэн хөрш зэргэлдээ орны ард түмний хоорондын түүхэн хэлхээ холбооны үндсэнд зөвхөн газар зүйн ойр дөт байдал, соёл, эдийн засгийн нэгдмэл шинж төдийгүй, удам угсаа, хэлний ураг төрлийн холбоо оршиж байгаа юм. Жишээ нь: Хойт Баруун, хойт Зүүн хойт Хятадад нутаглаж байгаа уйгур, казах, киргиз, узбек, татар болон бусад ястнууд түрэг угсаатны бүлэгт, монгол, дагуур, дүнсян зэрэг ястан монгол угсаатны бүлэгт тус тус хамаарч байна. Манж, сибо, нанай, эвэнк, хамниган болон бусад ястан түнгүс-манж угсаатны бүлэгт хамаарна. Хятадын өмнөт, баруун урд хэсэгт оршин сууж байгаа ястнууд бол чжуантай, төвд-бирм мөн кхемер угсаатны бүлэгт хамаарна.

БНХАУ-ын баруун хойт хэсэгт (Синьцзян) оршин сууж байгаа ард түмэн өөрийн баялаг өвөрмөц түүхтэй бөгөөд саяхан болтол Хятадын түүхийн үйл явцаас төдий л хамаарахгүй хөгжиж ирсэн байна. Эдгээр ард түмний дийлэнх нь Төв Азийн улс төр, соёлын амьдралд үлэмжхэн үүрэг гүйцэтгэж байсан, эртний түрэг угсаатны нэг болох уйгурууд юм. Уйгурууд эрт үеэс Зүүн Туркестакыг (хожим хятадууд Синьцзян хэмээн нэрлэсэн) бүхэлд нь эзлэн тогтнож байжээ. Тэд Зүүн Туркестанд нүүн суурьшихаасаа өмнө, тухайлбал IX зуунд Монгол нутагт хүчирхэг улс байгуулж байсан билээ. Уйгурын хаант улсын нийслэл Хар Балгас Орхон голын зүүн эрэгт байрлаж байлаа. Уйгурууд Монгол болон Төв Азийн бусад орны ард түмэнд соёлын их нөлөө үзүүлжээ. Согд үсгийн

<sup>1</sup>Мао Зэдүн Сысян ваньсуй. Пекин. 1967 г. Ишлэлийг үз: «Идейно-политическая сущность маоизма» М., 1977. 332-р тал

үндсэн дээр бий болсон уйгур бичгийг монгол, манж нар зээлдэн авсан байна.

Синьцзянд уйгуруудаас гадна казах, киргиз, тажик, узбек зэрэг ястнууд оршиж байдаг бөгөөд тэд угсаа гарал, соёл, хэлээрээ Зөвлөлтийн Дунд Азийн ард түмэнтэй илүү ойр ажээ.

Хэрэв түүхийн жинхэнэ үнэнийг хэлбэл, 1915 оны гурван улсын Хиагтын хэлэлцээрээр Өвөр Монголыг Хятадын харьяанд оруулсан сүүлийн үеийг хүртэлх Өвөр Монголын түүхийг нийт Монголын ард түмний түүх, БНМАУ-ын түүхээс салган үзэх ямар ч үндэс байхгүй юм. Тэр ч байтугай, Монгол орныг Гадаад Монгол, Дотоод Монгол<sup>1</sup> гэж хуваасан манжийн ноёрхлын үед ч Монгол орны хоёр хэсэг өөрсдийн ураг төрлийн болон бусад хэлхээ холбоогоо алдаагүй байсан бөгөөд аль аль нь булаан эзлэгчдийн дарлалын дор гашуун зовлонг хамт эдлэж байлаа. Монгол орны хоёр хэсгийн ард түмнийг манжийн булаан эзлэгчид, хятадын милитаристуудын эсрэг хандсан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон үндэсний ба нийгмийн эрх чөлөөний төлөө эрмэлзлэл тэмүүлэл юу юунаас илүү нэгтгэн ойртуулж байсан билээ. Ар Монголд ардын хувьсгал ялж, социалист Монгол улс үүсч буй болсноор БНМАУ нь Өвөр Монголын монголчуудад аз жаргал, эрх чөлөөт амьдралын хамгийн ойлгомжтой бодит үлгэр жишээ болж иржээ.

Хятадын хан биш ард түмнийг судлах асуудлаар 1978 оны 3-р сард Бээжинд хийсэн өргөтгөсөн бага хурал дээр Төвд орон хэзээ ямагт Эх орны, өөрөөр хэлбэл Хятадын нэг бүрэлдэхүүн хэсэг байсаар ирсэн гэдгийг нотлох тухай удирдамжийн заалтыг гаргажээ. Үүний зэрэгцээ Төвдийн архив, ялангуяа Төвдөөс Хятад болон бусад улсуудтай харилцаж байсныг харуулсан баримт бичгүүдэд бүр ч онцгой хяналт тогтоох шийдвэр гаргажээ. Маоистууд, Төвдийг ийнхүү онцгой анхаарах болсон нь энэ орны бодит түүхийг Хятадын одоогийн удирдлагын бодлого зорилтод ашигтайгаар нийцүүлэн тайлбарлахад тун их төвөгтэй байгаагаас шалтгаалж байгаа юм. Үнэн хэрэг дээрээ Төв Азийн эртний нэг ард түмний хувьд төвдүүд нь онцлог, шашин шүтлэг, өөрийн соёлоороо хятадуудаас ихээхэн ялгаатай билээ. Төвдүүд биеэ даасан төр улс, нийгэм-эдийн засгийн хөгжлийн баялаг түүхтэй нь бүхнээ тодорхой. Төвд эрт цагт ч Хятадын «хараат улс» байсангүй, хожуу үед ч хятадын «салшгүй хэсэг» байгаагүй юм. Төвдөд засаг төр нилээд эрт үед, тухайлбал манай эриний VII зуунд үүсч сүүлийн үе хүртэл аль нэг хэлбэрээр тогтож байгаад 1959 онд БНХАУ-ын Төрийн Зөвлөл, Төвдийн орон нутгийн засгийн газрыг тарааж, бүх засаг захиргааг нь Хятадын цэргийн хянан шалгах хороонд шилжүүлснээр маоистууд тус орны засаг төрийг устгасан болно. Төвдийн ард түмэн эртний өвөрмөц соёлтой. Бүр манай эриний VII зуунд эртний Энэтхэгийн нагари хэмээх бичгийн загвараар төвд бичиг зохиогдсон ажээ. Энэ бичгээр бичигдсэн асар олон орчуулгын болон эх зохиол байдаг бөгөөд тэд нь Төв Азийн ард түмний мэдлэг ухаан, соёл, түүхийг судлахад туйлын чухал ач холбогдолтой Маоист түүхчид Хятадын соёл төвдүүдэд зонхилох нөлөө үзүүлсэн мэтээр түүхийн үүднээс нотлохыг шургуу оролдож байна. Гэтэл Төвдөд нөлөөлсөн гаднын соёлын дотроос хамгийн их нөлөөтэй байсан нь Энэтхэгийн соёл байсан гэдгийг түүх гэрчилж байна. Энэ нөлөө зөвхөн шашны шинж чанартай байгаагүй юм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Төвд нь Азид эртний болон дундад зуу-

<sup>1</sup>Монголыг байлдан дагуулсан манж нараас анх удаа «Дотоод Монгол» гэж нэрлэсэн энэ томьёог монголчууд хэзээ ч хэрэглэж заншаагүй юм. Монголын тэр хэсгийг «Өвөр Монгол» гэж хуучнаар нэрлэсээр иржээ. (Халх Монголыг Ар Монгол» гэдэг шиг). Одоо ч гэсэн «Нэй мэнгү цзы чжи цюй» гэж хятадаар нэрлэдгийг «Дотоод Монголын өөртөө засах орон» гэж заншаагүй, харин «Өвөр Монголын өөртөө засах орон» гэж албан ёсоор нэрэлсээр байна.

ны Энэтхэгийн соёл шинжлэх ухааны ололтыг дэлгэрүүлэх, хадгалах, өвлөн залгамжлах үйлсэд гарамгай үүрэг гүйцэтгэжээ. Саяхан болтол Төвд Төв Азийн нилээд орны соёл, шашны төв нь болж байсан билээ. Ялангуяа Төвд, Монголын түүх, соёл, улс төр, шашны харилцаа хуучин цагт бүр ч нягт байсан удаатай.

Монгол ба Төв Азийн бусад орны соёлын харилцааны түүхэнд Төвд тэмдэглүүштэй онцлог үүрэг гүйцэтгэсэн юм. Төвд зөвхөн өөрийнхөө соёлын нөлөөг Монголд түгээсэн төдийгүй, мөн өөрөө эртний болон дундад зууны Энэтхэгээс зээлдэн авсан бүхнээ тус оронд дамжуулан өгсөн болохыг анхаарах нь чухал байна. Монгол хэлнээ байгаа Энэтхэгийн шинжлэх ухаан, утга зохиолын бүтээлийн дийлэнх нь төвд хэлнээс орчуулагдсан байна. Бүх Дундад Азид араб хэл, аль эсвэл Европд латин хэл тухайн үедээ чухал үүрэгтэй байсан шиг Монголд төвд хэл мөн тиймэрхүү ач холбогдолтой байсан гэж бид урьд өмнө бичиж байсан удаа бий. Тэр төвд хэл Монголд зөвхөн сүм хийдийн хэл байсан төдийгүй, мөн эрдэм мэдлэгийн хэлний үүргийг ч аль нэг хэмжээгээр гүйцэтгэж байв. Төвд хэлээр монголчууд олон зохиол, бүтээл туурвисан бөгөөд түүнийг бид төвд хэлний монгол утга зохиол гэж нэрлэсэн билээ. Эдгээр зохиолын дотор зөвхөн бүддийн шашны ном зохиолд хамаарагдахгүй, шинжлэх ухаан, уран зохиолд хамаарах бүтээл ч цөөнгүй байгаа юм. Төвд хэлний монгол утга зохиолыг Төвд даяар сайн мэддэг байсан бөгөөд түүнийг ч төвдийн сүм хийдэд ч цөөнгүй хэвлэдэг байв. Төвд, Монголын бичигтэн нарын дунд адилхан нэрд гарсан нийт дундын дуртай зохиолч, эрдэмтэд олон байжээ. Төвд хэлээр бүтээлээ бичдэг байсан монгол зохиогчдын дотор Төвдийн өөрийн нь зохиогчдоос дутуугүй Төвдөд алдаршсан хүмүүс цөөнгүй байжээ. Төвд хэлээр уншигчдын дунд доорхи зохиогчдын дотроос чухам хэн нь илүү алдартай байсныг хэлэхэд хэцүү байна. Түүхчдээс Хөх нуурын монгол Сүмбэ-ханба Ишибалжир буюу үзэмчин гүн Гомбожав уу, аль эсвэл Гос-лозава Шоннубал буюу Бутонринбочи уу?: философчдоос Алшаагийн монгол Дандар Лхарамба уу, аль эсвэл Жамьяншадби-Дорж уу?; яруу найрагчдаас Халхын ноён хутагт Равжай уу, эсвэл VI далай лам Цаенжамцо уу?

XVIII зууны сүүлчээр Хятад нь олон үндэстний улсын хувьд одоогийнхоо хил хязгаарын хэмжээнд бүрэлдэн тогтсон юм. Гэхдээ анхаарууштай нэг онцлог тал бол тэрхүү олон үндэстний улс нь хятад хүмүүсийн өөрсдийн нь хүчээр бус, харин хятад биш ястан болох манж нарын дундаас гарсан байлдан дагуулагч хаадын «нэгтгэн» захирах чармайлтын үрээр бий болсон гэдгийг түүх гэрчилж байгаа билээ. Манжийн хаад нь одоогийн маоист түүхчдийн нотлохыг оролдож байгаагаар Хятадын засгийн эрхийг олон үндэстний нэг нь нөгөөгөө «тайвнаар» «дараалан солих» замаар огт бус, харин олон жилийн туршид цус асгаруулсан, булаан эзлэх дайн дажныг явуулсан хүчээр л Хятад орныг эзлэн захирч тэнд харийн ноёрхлыг тогтоосон билээ. Манжийн булаан эзлэгчид олон жил үргэлжлэсэн цуст дайны явцад хөрш зэргэлдээ орнуудын асар уудам газар нутгийг эзлэн авсныг хэн ч сайн мэднэ. Тэрхүү дайны үеэр монгол, уйгур, төвд зэргийн ард түмний олон зуун мянган хүн хайр найргүй хядагдсан билээ. Манжийн ноёрхлын үед үндэстний хүнд дарлал байлдан дагуулсан ард түмний эсэргүүцэл дургүйцлийг төрүүлэн улмаар зэвсэгт тэмцэл ч цөөнгүй гарч байлаа. Үнэхээр манжийн ноёрхлыг эсэргүүцсэн ард түмэн, түүний дотор хятадын ард түмний тэмцлийн үр дүнд 1911—1912 онд манж Чин улс устсан билээ. Гэвч түүхэн олон нөхцөл шалтгаанаас болж хятад биш ястан ард түмэн зарим нэгээсээ бусад нь цөм Хятадын бүрэлдэхүүнд хэвээр үлдсэн юм. Эдгээр ард түмэн Хятадын цэргийн эрхтэн, гоминьданчуудын харгислалын үед хичнээн их хэрцгий ширүү-

нээр нухлагдан дарлагдаж байсныг хэн эс мэдэх билээ. Тийнхүү үндэстний асуудлыг бүх орны хэмжээгээр шийдвэрлэх явдал нь Хятадын улс төрийн цаашдын хөгжлийн явц, Хятадын хувьсгалын эцсийн үр дүнгээс шалтгаалах ёстой байлаа. Мао Зэдүн болон түүний талынхан Хятад дахь үндэстний цөөнхийн талаар явуулах их гүрний үндэстний дээрэнгүй бодлогоо дав даруйдаа шууд хэрэгжүүлж чадаагүй юм гэдгийг хэлэх хэрэгтэй. Үүний учир нь нэгдүгээрт, Хятадад ардын хувьсгал, ялах үеэр ХКН үндэстний талаар марксизм-ленинизмийн дагуу нилээд тодорхой боловсруулсан тусгай программтай байсан хийгээд хоёрдугаарт, Маогийн талынхан хятад биш ястнуудаас үндэстний болон нийгмийн эрх чөлөөний төлөө тэмцэлдээ олсон их амжилтыг өчүүхэн ч гэсэн анхааран үзэхгүй байж чадаагүйтэй холбоотой юм.

Хятадын ардын хувьсгалын ялалтын өмнө, үндэстний эрх чөлөөний хөдөлгөөний жилүүдэд ХКН нь туйлбартай интернационалист коммунистуудын ачаар марксизм-ленинизмийн ёсоор үндэстний асуудлын программыг ерөнхийдөө зөв зохистой боловсруулж чадсан юм.

Ардын хувьсгалын нэг үндсэн зорилт бол үндэстний өөрөө засан тогтнох эрхийн ленинч зарчмыг хэрэгжүүлэх явдал мөн гэдгийг тэр программд тунхаглав. Тухайлбал, 1923 онд ХКН-ын III их хурлаас баталсан улс төрийн программын VIII зүйлд өгүүлсэн нь: «Төвд, Монгол, Синьцзян зэрэг зах хязгаарын нутаг үндэстний тусгаар тогтнох эрхтэй болох ёстой бөгөөд гагцхүү хэрэв эдгээр нутгийн ард түмэн хүсвэл хятадтай нэгдэж болно»<sup>1</sup> хэмээн заасан юм. Үндэстний асуудлыг шийдвэрлэх ленинч зарчмыг Хятадын Зөвлөлт районуудын төлөөлөгчдийн Бүх Хятадын I, II их хурлаас хүлээн зөвшөөрч байгаагаа дахин нотолсон байна. Үндэстний асуудлаар Бүх Хятадын I их хурлаас (1931) баталсан тогтоолд өгүүлсэн нь: «Хятад биш үндэстний дарлал мөлжлөгийг «Хятадын ажилчин, тариачин, цэрэг, бүх хөдөлмөрчин олон түмэн, хятад биш үндэстнүүдийн дарлалыг шийдвэртэй эсэргүүцэж тэдэнд бүрэн эрх чөлөө олгохын төлөө тэмцэж байна. Үүний учир ажилчин, тариачин, цэргийн депутатуудын Зөвлөлүүдийн Бүх Хятадан I их хурал, Зөвлөлт Хятадын Бүгд Найрамдах Улс бүх үндэстний өөрөө засан тогтнох эрхийг үг дуугүй эрс шийдвэртэй зөвшөөрч байгаагаа тунхаглаж байна.

Өвөр Монгол, Төвд, Синьцзян, Юаньнань, Гуйчжоу зэрэг хүн амын дийлэнх нь хятад биш үндэстэн оршин суудаг районд эдгээр үндэстний хөдөлмөрчин олон түмэн, Зөвлөлт Хятадын Бүгд Найрамдах Улсын бүрэлдэхүүнээс гарч өөрийн тусгаар тогтносон улс байгуулах, эсвэл Зөвлөлийн Засагт Бүгд Найрамдах Холбоот Улсын бүрэлдэхүүнд орох буюу Зөвлөлт Хятадын Бүгд Найрамдах Улсын дотор автономит муж болох тухай эрхээ өөрсдөө шийдвэрлэх ёстой» гэжээ.<sup>2</sup>

ХКН-ын дэвшүүлсэн тэрхүү программ нь Хятадын бүх ард түмэн хувьсгалт тэмцэлд нэгдэн нягтрахад зохих хувь нэмрээ оруулсан нь мэдээж билээ.

Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улс болон бусад орны ард түмний аугаа их интернационалч тусламж дэмжлэг, Хятадын бүх ард түмний тэмцлийн үр дүнд Хятадын ардын хувьсгал ялалтанд хүрсэн юм. Тэр ялалт марксизм-ленинизм, ЗХУ болон социалист бусад орны баялаг туршлагын үндсэн дээр социализмын замд орж, үндэстний асуудлыг зөв шийдвэрлэх замыг хятадын ард түмэнд нээж өгсөн билээ.

Олонхи тохиолдолд Хятадтай төсөөтэй нийгэм-эдийн засаг, угсаатны ба соёлын нөхцөлд үндэстний асуудлыг үлгэр жишээчээр шийдвэрлэсэн

<sup>1</sup>Великодержавная политика маоистов в национальнх районах КНР. М., 1975, 4-р тал

<sup>2</sup>Советы в Китае. М., 1934. 440-р тал

Зөвлөлт Холбоот Улсын асар баялаг туршлагыг бүтээлчээр хэрэглэх явдал Хятад дахь үндэсний асуудлыг зөв зохистой шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой байх байсан билээ. Хятад оронд ардын хувьсгал ялах үед ЗСБНХУ-ын олон үндэстний ард түмэн, ЗХУКН-ын удирдлагын дор урагшаа) давшин өөрсдийн улс төр, эдийн засаг, соёлын хөгжилтөндөө гайхамшигт амжилтанд хүрээд байсан юм. Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс нь үндэстний бүрэн тэгш эрх, харилцан итгэх, харилцан туслах зарчимд тулгуурласан ард түмний жинхэнэ ахан дүүсийн найрамдал, нэгдэл, нягтралыг үнэн хэрэг дээрээ бий болгосон олон үндэстний социалист улсын сонгодог үлгэр жишээ болж байсан билээ. «Нэг үндэстэн нь нөгөөгөө огт дарангуйлахгүй бөгөөд туйлын төгс итгэл, ах дүүгийн нэгдлийг тодорхой ухамсарлах, бүрэн сайн дурын тохиролцоон дээр үндэслэсэн тийм холбоо болох үндэстнүүдийн сайн дурын холбоог бид хүсэж байна»<sup>1</sup> гэж В. И. Лениний хэлсэн мэргэн үг биелсэн байна.

Гэвч Мао Зэдүн болон түүнтэй нэг санаатнууд ЗХУ-ын аугаа их туршлагыг тоомсорлон үзээгүйгээр үл барам, үндэсний асуудлыг шийдвэрлэх талаар Хятадын Коммунист Намынхаа тунхагласан чухал зарчмаас ч татгалзсан байна. Тэд үндэсний асуудлын талаар социализмын эсрэг хандсан, их гүрний дээрэнгүй бодлогоо Хятадын Коммунист Намд тулган хүлээлгэж, ард түмнийхээ эсрэг адал балмад ажиллагаагаа хэрэгжүүлж дөнгөсөн юм. Гэвч тэр бодлого нь үндсээрээ балран нурахад хүрсэн тухай бид дор өгүүлэх болно.

Мао Зэдүн үндэсний асуудлын талаар хятадын нөхцөлд аль нэг хэмжээгээр тохирсон, нааштай программыг боловсруулж чадаагүй гэдгийг юуны өмнө хэлбэл зохино. Энэ нь ч ойлгомжтой хэрэг. Учир нь Мао Зэдүн үндэсний асуудлын тухай марксизм-ленинизмын сургаалаас урваж, социалист улсууд, юуны өмнө Зөвлөлт Холбоот Улсад үндэсний асуудлыг шийдвэрлэсэн түүхэн туршлагыг аль болохоор үл тоомсорлон гүтгэн гутаахыг чармайж байсан юм.

Мао Зэдүн болон түүний талынхан, бага үндэстний талаар баримталж байгаа их үндэсний дээрэнгүй бодлогод нь харшилж байгаа учраас үндэсний өөрөө засан тогтнох эрхийн тухай ленинч чухал зарчмаас юуны өмнө татгалзсан юм. Үүгээрээ тэд Хятад дахь социализмын үйл хэргээс үнэндээ урвасан байна. «Социализмын үед үндэстний өөрөө засан тогтнох эрхээс татгалзах нь социализмаас урвасан хэрэг болно»<sup>2</sup> гэж В. И. Ленин заасан байдаг.

Маоистууд, үндэстний өөрөө засан тогтнох эрхийн тухай ленинч зарчмын эсрэг, их гүрний үндэсний дээрэнгүй зорилгыг мөрдлөг болгон, районы үндэсний автономит эрх гэгч зүйлийг сөргөөн тавив. Маоистууд ард түмний эсрэг хандсан «районы автономит» эрхийн бодлогоо цагаатгахын тулд түүхийг зүсэн бүрээр гуйвуулан, хуурамч шинжлэх ухааны үзэл санаа, нотологоог гарган ирж байна.

1956 оны IV сард Мао Зэдүн хэлсэн нь: «Манай үндэсний цөөнх нь тооны хувьд олон биш бөгөөд өргөн уудам нутгаар тархаж суурьшсан байна. Тус орны бүх хүн амын 94 хувийг эзлэдэг хан үндэстэн тооны хувьд үлэмжхэн давамгайлж байна... Удаан хугацааны турш олон үндэстэн хутгалдан холилдсоны дүнд хан үндэстэн тоо хэмжээгээрээ том үндэстэн болжээ»<sup>3</sup>. Өөрийн үгийн их хан үндэстний дээрэнгүй үзлийн мөн чанарыг марксист хэллэгээр нуун далдлахыг хичнээн оролдлоо ч гэсэн Мао Зэдүний тэр үг нь мөн л хан үндэстний талаар Чан Кайшигийн хэлж байсан улигт үг яриаг санагдуулж байна. Чан Кайши хэлсэн нь: «Хятад

<sup>1</sup>В. И. Ленин. Түүвэр зохиол, 30-р боть, УБ., 1967. 283-р тал.

<sup>2</sup>В. И. Ленин. Түүвэр зохиол. 22-р боть, УБ., 1966, 341-р тал

<sup>3</sup>Мао Цзе дун. Избранные произ. т. 5, Пекин, 1977.

үндэстэн найралдан нэгдсэн амьд нэгдлийн хувьд төрөл бүрийн овгууд хутгалдан холилдох замаар үүсэн бүрэлджээ. Эдгээр янз бүрийн овгууд өөрсдийн гарал үүслээрээ нэгэн арьстан, нэгэн удам угсаанаас салбарласан бөгөөд Памирын тэгш өндөрлөгөөс дорно зүг, Хуанхэ, Хуайхэ, Чан-цзян, Хэйлунцзян, Чжунцзян зэрэг мөрнүүдийн хоорондох сав газрыг эзлэн тархсан юм...»<sup>1</sup> гэжээ.

Хятадад аль эрт цагаас эхлээд хуваагдашгүй нэгэн бүхэл бүтэн хятад үндэстэн байсан гэдгийг батлахад зориулагдсан «Дундад улсын үндэстэн» (Чжунхуа миньцзу)-ний тухай маоистуудын одоо өргөн сурталчилж байгаа онол нь өмнө дурдсан Мао Зэдүний баримтлал төдийгүй, мөн Чан Кайшигийн үзэл санаанд нэгэн адил тулгуурлаж байна. Хятадын хан биш ард түмнийг судлах асуудлаар хийсэн өмнө дурдсан бага хурал дээр Хятадад зөвхөн ганцхан «хятад үндэстэн» байдаг бөгөөд бусад ястнууд нь энэ нэгдмэл үндэстний «салаа мөчрүүд» мөн гэдэг үндсэн дүгнэлтийг дэвшүүлэв. Ийнхүү Чан Кайшигийн гаргасан үзэл санаа болон хуваагдашгүй нэгдмэл нэг хятад үндэстний тухай маоистуудын хийж байгаа «шинжлэх ухааны» дүгнэлт хоорондоо яв цав авцалдан тохирч байгаа нь ихээхэн сонирхолтой байна. Маоистууд үндэстний болон их гүрний хамгийн харгис дээрэнгүй үзэлтнүүдийн байр сууринд өнхрөн оржээ.

Мао Зэдүн хоцрогдсон улс түмэн капиталист биш хөгжлийн замаар хөгжих тухай Лениний сургаалыг огт үл тоомсорлон аль болохоор дуугүй тойроод өнгөрөхийг хичээдэг байлаа. Энэ нь бидний үзэж байгаагаар санамсаргүй зүйл огтхон ч биш бөгөөд Мао Зэдүний их гүрний үндсэрхэх үзэл нь хоцрогдсон ард түмэн дэлхийн тэргүүний улс түмэнтэй эн зэрэгцэн хөгжиж болох тухай Лениний их сургаалтай харшилж байгаа юм.

Мао Зэдүний олон тооны мэдэгдэл тухайлбал түүний нас барсны дараа Хятадын Коммунист Намын шинэ удирдлагынхны хэвлүүлсэн Мао Зэдүний V ботьд орсон бүтээлээс үзэхэд, Мао дарга үндэстний цөөнхүүдийн эзэлж байгаа газар нутгийн хэмжээ, мөн эдгээр нутгийн хөрсөн доорхи асар их баялгийг л юуны урьд сонирхож байснаас биш тэдгээр ард түмний өөрсдийнх нь нийгэм-эдийн засгийн хөгжлийн хувь заяаг өчүүхэн ч анхаарч байсангүй. Жишээ нь, Мао Зэдүн 1956 онд илэн далангүй хэлсэн нь: «Хэрэв тэд (ханчууд—Ш. Б.) их хан үндэстний дээрэнгүй үзлийг дэлгэрүүлээд, үндэстний цөөнхийг гадуурхах юм бол туйлын муу байхсан билээ. Хэн нь их илүү газар нутаг эзэмшиж байна вэ? Үндэстний цөөнхүүд. Тэдний оршин сууж байгаа нутаг дэвсгэр бүх орны нутгийн 50—60%-ийг эзэлж байна. Хятад улс өргөн их газар нутагтай, байгалийн нөөцөөр баян, асар их хүн амтай гэж бид ярьж байна. Гэвч үнэндээ хүн амын олонхи нь ханчууд, харин үндэстний цөөнх нь өргөн уудам нутагтай, байгалийн нөөцөөр баян байна, тэд дор хаяхад газрын гүний баялгаар ч баян байна»<sup>2</sup> гэжээ. Мөн тэр 1959 онд айлдсан нь: «Хятадад хэдэн арван ястан оршин суудаг. Үндэстний цөөнхийн нутаг хэмжээгээрээ ханчуудын эзэлж байгаа газар нутгаас илүү өргөн уудам, тэнд туйлын асар их материаллаг баялаг нуугдаж байна. Манай улс ардын аж ахуй үндэстний цөөнхийн эдийн засгийн оролцоогүйгээр байх нөхцөлгүй»<sup>3</sup> гэжээ.

Одоо хятад биш ард түмний хувьд явуулж ирсэн их гүрний, үндэстний дээрэнгүй маоист бодлого хэрхэн хэрэгжиж байсныг авч үзье. «Районы үндэстний автономит эрх» гэгч бодлого үнэн хэрэг дээрээ жижиг ард түмний өөрөө засан тогтнох эрхийг устгаж, тэднийг тарааж бутарган, хя-

<sup>1</sup>Чан Кайши. «Судьбы Китая» Лянхэ чубанше—1945 (на кит. яз.) стр. 353—354. Chiang Kai-shek. China's Destiny. New York. The Macmillan Company, 1947, p. 4

<sup>2</sup>Мао Цзе дун. Избранные произведения. Т. 5, 353-р тал

<sup>3</sup>Мао Цзе дун. Избранные произведения Т. 5, 271-р тал

тад биш ард түмнийг ханчуудын дунд уусгахад чиглэгджээ. Зарим нэг баримтыг дурдая. 1965 оны 9-р сард Төвдийн автономит районыг байгуулан тунхагласан явдал хэрэг дээрээ Төвдийг Хятадын бүрэн эрхшээлд оруулж, Төвдийн ард түмний үндэсний хамгийн энгийн эрхийг устгасны халхавч болжээ. Төвдийн автономит районыг байгуулсаны үр дүнд энэ орны үндсэн хүн ам засаг захиргааны янз бүрийн нэгжүүдэд хуваагдан тархай бутархай байдалд орсон юм. Төвдийн автономит районоос гадна Төвдтэй хил залгаа 9 автономит тойргийг бас байгуулсан байна. Энэ бодлогын уршгаар БНХАУ-д амьдарч буй бүх төвд хүн амын тал хувиас илүү нь Төвдийн автономит районы гадна үлдэж хоцорсон байна. Урьд хятад хүн бараг байгаагүй Төвдийн нутагт хятадуудыг олноор нүүлгэн суулгаж эхлэсэн билээ.

Хятадын удирдагчид Төвд оронд ёс төдий автономит район байгуулахдаа тун их бэрхшээлтэй тулгарч байсан юм. Тэд улс төрийн янз бүрийн зарчимгүй арга залиас эхлээд залхаан цээрлүүлэх дайны ажиллагааг явуулах зэргээр даруй 16 жилийн туршид чармайн оролдож байж сая өөрсдийн зорилгод хүрсэн билээ. Хятадыг эсэргүүцсэн Төвдийн ард түмний өргөн хөдөлгөөний дээд цэг болсон 1959 оны зэвсэгт бослогыг маоистууд хатуу ширүүнээр нухчин дарж, Төвдийн орон нутгийн засгийн газрыг устгаад, цэргийн маш хатуу хяналтын дор Төвдөд автономит район байгуулах ажилд шилжин орсон билээ. Хятад дахь нэг жижиг ард түмэнд газар нутгийн автономит эрх олгох үйл ажиллагаа иймэрхүү байдлаар явагдсан ажээ. Бусад автономит районуудад байдал үүнээс дээргүй байлаа.

Өвөр Монголын монголчуудын үндэсний эрх чөлөөний тэмцлийн явцад 1947 онд Өвөр Монголын автономит районыг байгуулсан билээ. Монголчуудад «ахан дүүсийн тусламж» үзүүлэн, монгол хүн оршин суудаг бүх нутаг дэвсгэрийг нэгэн районд нэгтгэх нэрийдлээр хятадууд оршин суудаг Суйюань (Жэхэ) муж, Нинся мужийн хэсгийг 1954 онд Өвөр Монголын нутагт оруулжээ. Энэ бүгдийн эцэст монголчууд өөрийнхөө автономит районд хүн амын цөөнх нь болж бүх хүн амын 8—10 хувиас илүүгүй болов. Өвөр Монголын нутаг 1,4 сая кв. км болж, хятадууд олширч хүн ам нь 9 саяд хүрэв.

Маоистууд «Соёлын хувьсгалын» үед «хувааж захирагтун» гэдэг өөрийн бодлогын жинхэнэ зорилтыг илчлэн харуулж, Өвөр Монголын хүн амын талаар туйлын бүдүүлгээр авирлан бас нэг арга хэмжээ авч явуулав. Маоистууд нутгийн хүмүүсийн саналыг огтхон ч харгалзахгүйгээр монголчуудыг хятадуудын дунд уусгах зорилгоо удирдлага болгон Өвөр Монголын зүүн хойт хэсэгт орших Хөлөнбуйр, Жирэм, Зуу-Уд гэдэг гурван аймгийг Хэйлунцзян, Цилинь, Ляонин зэрэг хятадын мужуудын бүрэлдэхүүнд нэгтгэв. Мөн Өвөр Монголын баруун хэсгийн үлэмжхэн нутгийг таслан аваад Ганьсу, Нинсяхуэйгийн автономит районы бүрэлдэхүүнд оруулав. Өвөр Монголын унаган газар нутгийг ийнхүү хэсэгчлэн хуваасны үр дүнд түүний газар нутаг 3 дахин бага болж, монголчуудын тоо 300 мянгад хүртэл цөөрч, Өвөр Монголын автономит районы хүн амын 3 хүрэхгүй шахам хувийг эзлэх болжээ. Монголчуудын ихэнхийг хятадын мужуудад тараан цацсан байна. Маоистуудын авч явуулсан эдгээр арга хэмжээ-ханчуудаас өөрсдийн үндэсний онцлогоороо эрс ялгаатай, эртний угсаа гаралтай ястнуудын нэгийг хүчээр уусгахад зориулагдсан нь тодорхой<sup>1</sup>.

<sup>1</sup> 1979 оны 7-р сард ХКН-ын Төв Хороо, Төрийн зөвлөл ӨМАР-ы засаг захиргааны 1969 оны 7-р сараас өмнө байсан хуваарийг сэргээх тухай шийдвэр гаргажээ. («Жэньминь жибао», 1979. 7. 21). Гэвч энэ нь маогийн чиг шугамын нэр нөлөөгөө нэгэнт алдсан хамгийн гажигтай бөгөөд хүний нүдэнд давын өмнө өртөгдөхүйц зүйлийг өөрчлөх гэсэн зөвхөн хэлбэрийн төдий оролдлого болно. (Ред.)

Сүүлийн хориод жилийн турш маоистуудаас Хятадад цэргийн хүнд сурталт диктатурыг тогтоох зорилгоор зохион явуулсан улс төрийн болон бусад олон явууллага нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын үндэстний районуудын ард түмний амьдралын бүхий л салбарт бүр ч илүү их хөнөөлт хор уршиг тарьсан юм. Мао Зэдүн нь 1956 онд хуралдсан ХКН-ын VIII их хурлын дараагаар удалгүй үндэстний районуудыг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн программыг хэрэгжүүлэх ажлыг бүрмөсөн сарниулан зогсоож өөрийн хувийн «онцгой бодлого» гэгчийг хятадад тулган хүлээлгэж амжсан юм. Мао Зэдүн болон түүний нэг санаатнуудын тэр бодлого Хятадад социализм байгуулах үндсэн шугамаас ухарсныг харуулахын зэрэгцээ их хан үндэстний үзэл урьд үзэгдээгүйгээр дур зоргоороо авирлах болсныг илтгэн харуулав. «Баруунтантай» тэмцэх кампанийн явцад «орон нутгийн үндсэрхэх үзэлд» гүтгэгдсэн үндэсний боловсон хүчний дунд үй олноор нь залхаан цээрлүүлэх цэвэрлэгээ хийж байлаа. Ардын коммуны «хурдан нэвтрэлт», «их үсрэлт» гэгчийн үеэр үндэсний районуудын эдийн засаг онцгой их бэрхшээл хохирол үзэв. Бээжингийн удирдлага нь хятад биш ард түмнийг хүчээр уусгах зорилготой, ард түмний эсрэг бодлогоо илээр явуулахдаа «үндсэн араг яс нь» болох ёстой ханчуудтай ястнууд нэгдэн нийлэх бодлогыг хурдасгах үзэл санааг өргөн сурталчилж байв. Тэр ч байтугай маоистууд хүчээр уусгах бодлогоо ичгүүр сонжуургүйгээр «марксист», «коммунист» бодлого гэж нэрлээд, тэр бодлогын эсрэг тэмцсэн хүн бүхнийг социализм, коммунизмын дайсанд тооцож байсан байна.<sup>1</sup> Хятадуудыг яаралтай үй олноор нь үндэсний районуудад нүүлгэн суулгах ажлыг зохиосноор хятад хүний тоо нутгийн хүн амаас үлэмжхэн давж ирсэн бодит баримт маоистуудын «марксист» ёсоор уусгах бодлогын жинхэнэ мөн чанарыг илтгэж байна.

Бүх орны хэмжээгээр асар их хохирол учруулсан «соёлын хувьсгалын» үр дүнд үндэсний районуудын байдал бүр илүү их хөөрхийлэлтэй хүнд байв. Хувьсгалын эсрэг улс төрийн кампанийн тэр жилүүдэд маоистуудын үндэсний улс төрийн бодлогын их гүрний дээрэнгүй үзлийн харгис мөн чанар улам тодоор илэрсэн юм. Чухамхүү тэр үед хятад биш ард түмний ор нэрийн төдий автономит эрхийн үлдэгдлийг ч алга болгожээ. Үндэсний районуудад засаг захиргааны хууль ёсны байгууллагыг хөөн тараагаад, бүх эрхийг Бээжингээс зориуд илгээсэн цэргийн эрхтэн хятадуудын гарт шилжүүлэв. Үндэсний бүх районд маогийнхний танхай залуучууд, «улаан хамгаалагчид» урьд өмнө үзэгдээгүй ихээр дур зоргоороо авирлаж байв. Бүх боломжийн улс төрийн хуурамч ял тулган олон мянган энгийн номхон хөдөлмөрчид, үндэсний сэхээтэн, боловсон хүчнийг нийтээр нь залхаан цээрлүүлж, золиосонд гаргаж байв. 1967 оноос эхлэн маоистууд «хувьсгалт хороод» гэгч засаг захиргааны шинэ байгууллагуудыг байгуулж эхлэсэн юм. Автономит районуудад «хувьсгалт хороод» нь маоистуудаас «соёлын хувьсгалын» жилүүдэд Хятад орон даяар тогтоож байсан цэргийн хүнд суртлын диктатурын үндэсний байгууллагын үүргийг гүйцэтгэх ёстой байлаа.

Нийт Хятадын хувьд ялангуяа үндэсний районуудын хувьд «соёлын хувьсгал» чухам хэрхэн яаж дууссаныг хэн эс мэдэх билээ. Үнэн хэрэг дээрээ үндэсний автономит байдлыг устгаж, эдийн засгийг сүйрэлд оруулж, хүн амын аж байдлын түвшинг эрс доройтуулсан маоистуудын их хан үндэстний илт дээрэнгүй бодлого нь бүх үндэсний районуудад хятад биш ард түмний хүчтэй эсэргүүцэл, үй олны жигшил дургүйцлийг төрүүлсэн юм. Маоист үндэсний бодлого бүрэн нурсныг «соёлын хувьсгал» юунаас ч илүү тодорхой харуулав. Хятадын автономит районуудын байдал маоистуудад онцгой аюултай болж, их хан үндэстний юугаар ч хал-

<sup>1</sup> «Синьцзян жибао» 1960. III. 21.

халж нуугаагүй дээрэнгүй бодлогыг цаашид үргэлжлүүлэх нь улам их аюул заналтай болов. Чухам ийм учраас Хятадын шинэ удирдлага «дөрвийн бүлгийнхнийг» зайлуусныхаа дараа үндэсний бодлогодоо арга буюу зарим нэг засвар оруулж, үндэсний асуудлыг Хятадыг шинэтгэх алсын шинэ зорилгодоо нийцүүлэн тохируулахын тулд үндэсний бодлогод арай уян зөөлөн болгоомжтой хандах гэж оролдох болов. Гэхдээ Хуа Гофэн болон түүний талынхан «Мао тэргүүлэгчийн үндэсний бодлогын» зарчмыг махран хамгаалсаар байгаа бөгөөд Хятадын эрх баригчдаас үндэсний районуудад явуулсан их гүрний хэтэрсэн илт дээрэнгүй үйл хэргийн бүх хариуцлагыг Линь Бяо болон «дөрвийн бүлэгт» тохох гэж оролдсоор байна. Энэ бүхэн нь Хятадын одоогийн удирдлага нэр сүрээ нэгэнт гутаасан «Мао тэргүүлэгчийн үндэсний бодлогыг» олны нүдний өмнө аварч улмаар үндэсний асуудлын талаар явуулж байсан хан үндэстний дээрэнгүй үзлийн илэн далангүй илрэл, хэтэрхий бүдүүлэг алдаанаас биеэ зайлуулах замаар үндэсний районууд дахь ээдрээтэй хүнд байдлыг аль нэг талаар засахыг чармайж байгааг гэрчилж байна. Хятадын эрх баригчдаас үндэсний районуудад явуулсан үндэсний дээрэнгүй бодлого хичнээн их хор хөнөөл тарьсныг гэрчлэх олон баримт одоо «дөрвийн бүлгийнхнийг» шүүмжлэх явцад илрэн тарсаар байна. «Жэньминь жибао» сонин 1978 оны 10-р сарын 20-ны дугаарт Линь Бяо, «дөрвийн бүлгийнхний» үндэсний бодлогыг «феодал-фашистын харгис» бодлого гэж тодорхойлжээ. Хятадын сонинуудын хуудаснаас «зарим газарт хан үндэстний хариуцлагатай ажилтны үндэсний автономит тойргуудыг өөрсдөө дур мэдэн татан буулгасан»<sup>1</sup> гэх буюу Хятадад «үндэстнүүдийн хэл, бичгийг хавчин устгаж», «хан бус үндэстнүүдэд өөрийн бичиг үсгээ хэрэглэхийг нь хорьсон төдийгүй, төрөлх хэлээрээ ярихыг ч хориглож байв»<sup>2</sup> гэх мэтчилэн бичих боллоо. «Дөрвийнхнийг» шахан зайлуулах үе хүртэл үндэсний районуудад явуулж байсан бодлого нь эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, техник, эрүүлийг хамгаалахын хөгжлийг таслан саатуулав гэж Хятадын хэвлэл хүлээн зөвшөөрч байна. Үндэсний боловсон хүчин бэлтгэх үйл хэрэгт хор учруулж эдгээр боловсон хүчнийг бусниулан сүйтгэлээ.<sup>3</sup>

Хэрэв дээхэн үед хятадын суртал ухуулга Хятад оронд үндэсний асуудал нэгэнт шийдвэрлэгдсэн гэж нотлохыг оролдож байсан бол одоо бүх дэлхийн хэмжээгээр үндэстэн устгах алс хэтийн хугацааны тухай догматик яриа дэлгэж эхэллээ. Үүнтэй холбогдуулан энэ оны 4-р сарын 6-нд «Жэньминь жибао» сонины дугаарт нийтлэгдсэн «Социализмын үед үндэсний асуудал удаан хугацаанд оршиж байх» тухай тусгай өгүүллийг дурдах хэрэгтэй.

Үндэсний бодлогыг явуулахад гарсан урьдын бүх алдаа, ялт хэргийг өөрсдийн улс төрийн дайснуудад тохон оноох аргаар одоогийн Хятадын удирдагчид үндэсний районууд дахь зохисгүй байдлыг засч, хан биш үндэстний дургүйцлийг намжааж, өөрсдийн явуулж буй үндэсний бодлогоо илүү намба төрхтэй болгох гэж аль болохоор хичээж байна. Мөн үүний хамтад тэд үндэсний асуудлын тухай маоист заалтуудын үндсийг юу боловч хөндөхгүй өнгөрөхийг чармайж байна. Тэд БНХАУ-дахь үндэстэн хоорондын харилцааг «сайжруулах», үндэсний районууд дахь «соёлын хувьсгал» мэтийн улс төрийн кампанийн хор уршгийг арилгах талаар зарим нэг арга хэмжээ авч эхлэж байна. Хан биш ард түмнийг ухуулан боловсруулах үйл ажиллагаагаа Бээжингийнхэн улам хүчтэй болгож байна. Үндэсний районуудын асуудлын талаар бичиж, ярих нь их боллоо. Бээжингийн удирдлага, хан биш ард түмний талаар «анхаарал» тавьж

<sup>1</sup> «Гуанмин жибао». 1978. I. 30; «Жэньминь жибао» 1979. IV. 6.

<sup>2</sup> Мөн сонин, 1977. III. 25.

<sup>3</sup> Мөн сонин, 1979. IV. 6.

байгаа дүр үзүүлэхийг элдвээр оролдох болов: Үндэстний цөөнхийн төлөөлөгчидтэй Хуа Гофэн болон бусад удирдагчид уулзах буюу үндэсний районуудаар ч аялан явах болов. 1978 онд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлын чуулганаар баталсан БНХАУ-ын шинэ үндсэн хуулинд 1954 оны үндсэн хуулиас үндэсний бодлогын зарчим, хан биш үндэстний эрх чөлөө, эрхийн холбогдол бүхий зарим зүйл, ангийг сэргээн оруулав. Тийнхүү хан биш үндэстний үндсэн хуулийн эрх, эрх чөлөөг шууд хассан 1975 оны үндсэн хуулинд үлэмжхэн өөрчлөлт оруулахад хүрчээ. Сүүлийн үед хан биш ард түмний эрх, тэдний үндэсний соёл, хэлийг сэргээх талын арга хэмжээнүүдийг өргөн сурталчилж байна. Нэг үгээр хэлэхэд, эдүгээ ХКН-ын удирдлагын үндэсний бодлого засарч, хятад биш ард түмнүүдийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзлэлд нийцэж байгаа мэтээр Бээжингийнхэн ярьж, сурталчлах болов. Үнэн хэрэг дээрээ энэ нь тийм биш байгаа юм. Баримтыг авч үзье. Хятадын удирдлага урьдын адил үндэстний цөөнхийг хятадчилах нөхцлийг аль болохоор бүрэлдүүлэхийн тулд хятадуудыг үй олноор нь хүчээр үндэстний районуудад шилжүүлэн суулгах ажлаа улам өргөжүүлж байна. Хятадын хил орчмын мужууд болох Синьцзян, Өвөр Монгол, Төвд, Гуанси-Чжуаны автономит районд хятадуудыг шилжүүлэн суулгахад онцгой анхаарал тавьж байна. Эдгээр районуудад юуны өмнө халагдсан цэргийг явуулж байгаа бөгөөд хятадын хэвлэлийн илэн далангүй бичиж байгаагаар тэдгээр нь «Үндэсний районуудад баттай идээшин суурьших ёстой» ажээ.

Үндэсний районуудад бүх удирдах тушаалыг зөвхөн хятадууд эзэлж байгаа явдал үндэсний асуудлын талаар Бээжингийн жинхэнэ санаа бодлого, суртал ухуулгын үг хэл хоорондоо гүн гүнзгий зөрчилтэй байгааг гэрчилж байгаа юм. Үндэсний боловсон хүчинд зөвхөн хоёрдугаар зэргийн цөөн албан тушаал оногдож байна. Автономит районы намын хороо, хувьсгалт хороодыг холбогдох цэргийн тойргийн толгойлогч хятад хүмүүс удирдаж байна.

Хятад дахь үндэстэн хоорондын харилцааг «цэгцлэх» талаар Хятадын удирдлагын авч явуулж буй зарим нэг арга хэмжээ нь үндэсний районуудад Бээжингийнхний тун холыг санаархсан стратегийн жанжлах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүрэн чиглэгдсэнээс биш, эдгээр районы уугуул оршин суугчдын амин чухал асуудлыг шийдвэрлэхэд огтхон ч зориулагдаагүй болохыг хэлэх хэрэгтэй. Энэ тухай Хуа Гофэний үндэсний асуудлаар илэн далангүй хэлсэн үг гэрчилж байна. Үндэсний асуудлаар Хуа Гофэний гаргасан удирдамжийн чанартай заалтад «Хятадын үндэстний цөөнх бол тооны хувьд олон бөгөөд ихэнхдээ хилийн дагуу амьдарч байна. Ийм учраас үндэстний цөөнхүүдийн дунд явуулж байгаа ажлыг цэгцлэх нь маш чухал байна»<sup>1</sup> гэжээ. Ийм санаа ХКН-ын XI их хуралд Хуа Гофэний тавьсан тайлан илтгэлд ч тусгагдсан байна. «Хил орчмын районууд, үндэстний цөөнхүүдийн дунд зохиож байгаа ажлыг цэгцлэхийн чухлыг» Хуа Гофэн цохон тэмдэглэсэн билээ.<sup>2</sup> Хэдийгээр ХКН-ын тус их хурал VIII их хурлын дараагаар үндэсний бодлогын зарим нэг асуудлыг хөндсөн анхны их хурал байсан боловч, тэр нь зөвхөн суртал ухуулгын чанартай тунхаглал, уриалгаар бүх асуудлыг хязгаарлаж, Хятадын хан биш үндэстний эрх ашиг, амьдралын хэрэгцээт шаардлагыг хангахад чиглэсэн ямар нэг тодорхой, практик арга хэмжээг боловсруулан дэвшүүлж чадаагүй юм.

1978 оны 2-р сарын 26-ны БХАТХ-ын чуулганд тавьсан илтгэлдээ Хуа Гофэн хан биш ард түмний эдийн засаг, соёлын бүтээн байгуулалтанд тусламж үзүүлэх асуудлыг «улсыг батлан хамгаалах хүчийг зузаат-

<sup>1</sup>«Гуанмин жибао» 1977. VII. 15.

<sup>2</sup>«Жэньминь жибао» 1977. VIII. 23

гаж, зах хязгаарын районуудын бүтээн байгуулалтыг хүчтэй болгох»<sup>1</sup> программтай нягт холбон үзжээ. Хятадын хил орчмын болон үндэсний районууддаа Хятадын удирдлагаас одоо явуулж байгаа улс төрийн бодлогын нэг гол онцлог нь гэвэл эдгээр нутаг газрыг урьд өмнө үзэгдээгүй ихээр цэрэгжүүлж байгаа явдал мөн бөгөөд үүнээс болж хятад биш үндэстнүүдийн нийгэм-эдийн засгийн хөгжил ихээхэн саатаж бэрхшээлд учирч байгаа ажээ. Бээжингийн удирдагчид үндэстний районуудын байгаль, хүний нөөцийг бүхэлд нь цэрэгжилт, дайны бэлтгэлийн зорилгод захируулан дайлчилж байна. Хөх хотод болсон ардын төлөөлөгчдийн хурлын чуулган дээр Өвөр Монголын «Хувьсгалт хорооны» дарга, Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга агсан Ю Тай Чжун, «дайны бэлтгэлийг бүхий л талаар хүчтэй болгох, бүх районы ард түмэн, арми хоёрыг байлдааны байнгын бэлэн байдлаар хүмүүжүүлэх, арми ард түмний харилцан үйлчлэх ажиллагааг хүчтэй болгох хэрэгтэй»<sup>2</sup> гэж хэлж байв. «Жэньминь жибао» сонин өөрийн хуудсандаа Өвөр Монголыг «империализм, ревизионизмын эсрэг болд цайз болгох»<sup>3</sup> зорилтыг дэвшүүлж байв.

Синьцзян-уйгурын автономит районы толгойлогч Ван Фэн, 1978 оны 2-р сард болсон районы ардын төлөөлөгчдийн хурлын чуулган дээр «Бид заавал сонор сэрэмжээ зуу дахин нэмэгдүүлж, хил хязгаар, эх орноо хамгаалах ажлыг хүчтэй болгож, түрэмгийллийг няцаахад зохион байгуулалт, үзэл санааны болон чанарын хувьд эмх цэгц бүрэн тогтоох ёстой»<sup>4</sup> гэж мэдэгдэж байв. Хил хязгаарын районуудад цэргийн олон том анги бүлгийг байрлуулав. Жишээлбэл, Төвдөд цэргийн тоо 350 мянгад хүрч байна. (Районы бүх хүн ам ердөө л 1,700 мянга болно). Синьцзянд цэргийн тоо сая гаруй байна. Гадаадын хэвлэлийн мэдээнээс үзэхэд БНМАУ, ЗСБНХУ-тай залгаа орших Хятадын нийт хилийн дагууд 2,400 мянган цэрэг өөрөөр хэлбэл Хятадын армийн дийлэнх нь бөөгнөрөөд байна. Эдүгээ үндэсний районууд нь цэргийн бааз, нисэх онгоцны буудал, цэрэг-стратегийн холбогдолтой замаар бүрхэгдээд байна. Хоргодох байр, газар доорхи хадгалах байр зэргийг эрчимтэй байгуулж, пуужинт-цөмийн зэвсгийн төхөөрөмжийг байрлуулж байна. Цэрэг-стратегийн чухал ач холбогдол бүхий Синьцзян, Кашмирын хооронд Каракорумын авто засмал зам тавьжээ. Энэ замыг тавьсан нь Энэтхэгийн хувьд аюултай хор уршигтай болохыг саяхан Энэтхэгийн ерөнхий сайдын орлогч Батлан хамгаалах яамны сайд Дж. Рамзаан тэмдэглэжээ. Энэ оны 5-р сарын эхээр Энэтхэгийн «Пэтриот» сонин, Энэтхэгтэй хил залгаа Пакистаны районуудад шинэ цардмал замуудыг тавьж эхлэлээ гэж мэдээлэв. Зам тавих газруудад Хятадын барилгын 30 мянган ажилчин очсон ажээ. Бээжингийнхний сүүлчийн мэдэгдэл, үйл ажиллагаанаас нь үзвэл шинэ засмал зам цэрэг-дайны үүрэгтэй болох нь ямар ч эргэлзээ төрүүлэхгүй байгаа тухай уг сонинд заажээ.<sup>5</sup> Үндэсний районуудын хөдөлмөрийн чадвартай бүх хүн амыг дайнд бэлтгэж, цэрэг дайны объектуудыг барьж байгуулахад нэг бүрчлэн дайчлах ажлыг зохиож байна. Бараг бүх эрэгтэй, эмэгтэйчүүдийг «өрхийн цэрэг» гэгчийн анги салбаруудад оруулан авчээ.

Хятадын шинэ удирдлага арга хэмжээ авч явуулж байгаа боловч БНХАУ-ын үндэсний районуудад байдал урьдын адил үлэмжхэн ээдрээтэй, хурцадсан хэвээр байна. Синьцзян, Өвөр Монгол болон Хятадын бусад районд «хувьсгалын эсэргүү, ангийн дайсны өдөөн хатгах, хагалан бутаргах үйл ажиллагаанд шийдвэртэй цохилт өгөгтүн!» гэсэн санд-

<sup>1</sup> «Жэньминь жибао» 1978. III. 7.

<sup>2</sup> Мөн сонин, 1977. VIII. 2.

<sup>3</sup> Мөн сонин, 1978. II. 12.

<sup>4</sup> «Жэньминь жибао» 1978. II. 12.

<sup>5</sup> «Правда» 1979. V. 3.

рангуй уриалгууд цөөнгүй дуулдах болов. Үндэсний районы эдийн засаг үлэмжхэн бэрхшээлтэй тулгарч байна. Ялангуяа хөдөө аж ахуй үнэхээр хөөрхийлэлтэй байдалд оршсон хэвээр байна. Шилжин ирсэн ханчууд, цэргийн тоо үндэсний районуудад олшрон, хүн, материалын нөөцийг цэргийн хэрэгцээнд их дайчилж байгаагийн улмаас үндэсний районы хөдөлмөрчин олны аж амьдрал улам бүр доройтсоор байна. Тэр ч байтугай үндэсний районуудад нүүлгэн суулгасан хятадуудын байдал ч төдий л амар үгүй байна. Энэ учраас тэдний дунд одоогийн байдалд дургүйцэх, төрөлх нутагтаа буцах гэсэн шаардлага хүчтэй болж байна. Энэ талаар «Жэньминь жибао» сонинд «Яагаад барилгачид Хятад руу буцаахыг шаардаж байна бэ»<sup>1</sup> гэсэн өгүүлэл гарсан нь сонирхолтой. Энэ өгүүлэлд, хорин жилийн өмнө эх орны умард хил хязгаарын районы бүтээн байгуулалтад оролцохоор Өвөр Монголд ирсэн олон тооны хятад хүн эдүгээ өөрсдийгөө Хятад руу буцаахыг шаардаж байна. Тийм шаардлагын үндсэн шалтгааныг хил хязгаарын районуудад «сэхээтний талаархи бодлого хэрэгжихгүй байгаатай» холбон Жэньминь жибао сонин тайлбарлажээ. Ийм учраас тэнд сэхээтнүүдэд мэдлэг, хүчээ зориулах газар алга байна. Өвөр Монголд шинжлэх ухаан, техникийн 16000 орчим ажилтан мэргэжлийн ажилгүй байна. Тэдний дунд олон гэр бүлийн эхнэр, нөхөр хорь гаруй жилийн турш өөр өөр газар, бие биеэсээ хол тусдаа амьдарч байгаа ажээ.

Ийнхүү хэдийгээр зарим нэг тактикийн шинэ арга, заль мэх гаргаж байгаа боловч өнөөгийн хятадын удирдлагын үндэсний бодлого нь Мао Зэдүний их хан үндэстний дээрэнгүй бодлогыг л Хятадыг шинэтгэн цэрэгжүүлэх шинэ шаардлага, нөхцөлд зохицуулан тохируулж үргэлжлүүлэн явуулахад чиглэгдсэн байна. Ийм учраас Мао Зэдүний нас барсны дараа Хятадын эрх баригчид үндэсний асуудлаар ямар нэгэн мэдэгдэхүйц нааштай өөрчлөлт хийжээ гэж хэлэх үндэс бидэнд огтхон ч алга байна. Үндэсний районуудад явуулж байгаа Бээжингийн бодлого бол одоо ч гэсэн үндэсний районуудын амьдралын бүх талыг цэрэгжүүлэх, хятад биш ард түмнийг хүчээр уусгах хэргийг хүчтэй болгон түргэвчлэхэд чиглэгдсэн их хан үндэстний дээрэнгүй бодлого мөн хэвээр байна гэж тодорхойлон хэлж болох байна.

Бээжингийн эрх баригчид хөрш зэргэлдээ социалист Вьетнам улсын эсрэг ялт дайн өдөөх хүртэл эзлэн түрэмгийлэх ажиллагаагаа идэвхжүүлж үндэсний районуудыг хэрэг дээрээ цэргийн лагерь, түгшүүртэй байдлын голомт болгон хувиргасан нь маоист үндэстний харгис бодлого Ази тив төдийгүй, даян дэлхийн энх тайвны үйл хэрэгт хичнээн их аюултай болж байгааг илтгэн харуулж байна. Нөхөр Ю. Цэдэнбал өгүүлсэн нь: «Хятадын эрх баригч бүлгийнхэн эзлэн түрэмгийлэх санаархлаа хэрэгжүүлэх зорилгоор дахин цэрэг дайны адал балмад түрэмгийлэл үйлдэхгүй гэхийн баталгаагүйг тэдний улс төрийн бодлого, практик ажиллагаа нотолж байна. Энэ бол Хятадтай хил залгаа оршдог ямар ч орон Хятадын эрх баригчдын түрэмгий явууллагын бай болж болзошгүй гэсэн хэрэг юм. Хятадын эрх баригчдын бодлого Азийн улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд хийгээд энх тайван, олон улсын аюулгүй байдлын үйлсэд ноцтой аюул занал учруулж байгааг дээрх баримтууд гэрчилж байна»<sup>2</sup> гэжээ.

<sup>1</sup>«Жэньминь жибао» 1979. II. 23.

<sup>2</sup>Ю. Цэдэнбал. МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр хэлсэн үг. «Намын амьдрал» сэтгүүл, УБ. 1979. № 6.

## МАОИЗМ И НАЦИОНАЛЬНЫЙ ВОПРОС В КНР

## Резюме

Одним из наиболее враждебных марксизму-ленинизму идейно-политических течений современности является маоизм-идеология и политика нынешних китайских лидеров. События сегодняшних дней воочию свидетельствуют об открытом переходе маоизма на позиции мировой империалистической реакции и об углублении его антисоциалистического, контр-революционного характера. Маоизм ныне представляет собой мелкобуржуазное которого является великодержавный национализм, принявший уродливую форму воинствующего гегемонизма и реакционного социалшовинизма.

Антинародная и реакционная сущность великоханьского шовинизма ярче всего проявилась в подходе маоистов к национальному вопросу. На подход маоистов к национальному вопросу больше всего и непосредственнее всего оказала воздействие конфуцианская этноцентристская концепция, веками являвшаяся теоретической основой великоханьского шовинизма для всякого рода реакционеров и националистов в Китае.

Автор отмечает, что в условиях Китая правильное решение национального вопроса представляло собой весьма сложную проблему. В этой связи, автор подчеркивает, что для правильного решения национального вопроса в Китае особенно важное значение имело бы творческое применение богатейшего опыта Советского Союза, образцово решившего данный вопрос в идентичных во многом с Китаем социально-экономических и этнокультурных условиях.

Однако Мао Цзедун и его единомышленники не только пренебрегли великим опытом Советского Союза, но и отказались от провозглашенных самой КПК важнейших принципов решения национального вопроса. Им удалось навязать партии свой антисоциалистический великодержавно-шовинистический курс по национальному вопросу и провести авантюристические, антинародные практические меры по осуществлению этого курса. Великодержавно-шовинистическая политика маоистов в отношении некитайских народов особенно ярко проявилась в годы «культурной революции». Именно в этот период остатки куцых прав автономии некитайских народов были сведены на нет. «Культурная революция» нагляднее всего продемонстрировала полное банкротство маоистской национальной политики.

Приписывая все прежние пороки и преступления в проведении национальной политики своим политическим противникам, нынешнее китайское руководство всячески изощряется наладить неблагоприятную ситуацию в

национальных районах, успокоить недовольство неханьских народностей и тем самым придать своей национальной политике более или менее респектабельный вид, не затрагивая при этом порочных основ маоистских установок по национальному вопросу.

Характернейшей особенностью политики нынешнего китайского руководства в национальных, пограничных районах является небывалое усиление милитаризации их, что, естественно, служит главной помехой нормализации жизни некитайских национальностей, обеспечению их социально-экономического развития.

Автор указывает на то, что национальная политика теперешнего китайского руководства, несмотря на некоторые новые тактические приемы и маневры, целиком и полностью направлена на продолжение великоханьского, шовинистического курса Мао Цзедуна по национальному вопросу применительно к новым требованиям и условиям модернизации и милитаризации Китая. Поэтому, подчеркивается в статье, нет никаких оснований говорить о сколько-нибудь существенных, положительных изменениях в национальной политике китайских властей после смерти Мао Цзедуна и устранения «группы четырех».

Политика Пекина в национальных районах сегодня по-прежнему может быть охарактеризована как великоханьская и шовинистическая, она направлена на форсирование насильственной ассимиляции некитайских народов и китаизации всех сторон жизни национальных районов.

В заключение автор подчеркивает, что активизация гегемонистских и экспансионистских действий Пекина вплоть до развязывания преступной войны против соседнего социалистического Вьетнама показала, что реакционная маоистская национальная политика китайских властей, превратившая национальные районы по существу в военные лагеря, очаги агрессии против соседних стран, таит в себе большую потенциальную опасность для дела мира и безопасности не только в Азии, но и во всем мире.